



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 24 өдөр

Дугаар 652

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн албан ажлын хэрэгцээнд зориулан үйл ажиллагааны давсан орлогын эх үүсвэрээр 180,000,000.00 (нэг зуун наян сая) төгрөгт багтаан 1 ширхэг автомашин худалдан авахыг зөвшөөрч, худалдан авах автомашины техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, төрийн захиргааны удирдлагын газрын дарга Т.Жамбалцэрэн, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн Захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батцэцэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн
652 дугаар тогтоолын хавсралт



**Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн худалдан авах автомашины
техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаар**

Д/д	Автомашины техникийн үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Суудлын автомашин /суудлын тоо 5, 3980-4200 cc хөдөлгүүрийн багтаамжтай/	ш	1	180,000,000.00	180,000,000.00
	Нийт үнэ		1		180,000,000.00 (нэг зуун наян)